САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2026 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Орхон аймаг

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Аймгийн Засаг даргын 2025 оны А/17 захирамжаар 12 орон тоотой байгууллагын стратеги төлөвлөгөөний **5 зорилгын** хүрээнд 2026 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг **7 зорилтын** хүрээнд **44 арга хэмжээг** төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1. Байгууллагын “Эрсдэлийн үнэлгээний журам”-ын дагуу 2026 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан **55** байгууллагаас 2026 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар **49** байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан, **6** байгууллагын хяналт шалгалт 30-90%-тай үргэлжилж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл:

Он	ДА, СХШ-ын /төлөвлөгөөт +төлөвлөгөөт бус тоо/	2026.11.27-ний өдрөөр батлагдсан удирдамжийн тоо	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	Дотоод аудит	Санхүүгийн хяналт шалгалт
2026	**55+4**	**59**	**55**	**4**	**30**	**29**





2026 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөр төлөвлөгөөт хяналт шалгалтын биелэлт шалгалт бүрэн дууссан 49 буюу **89%-тай** байна. **Тайлбар:** Хяналт, шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг өссөн дүнгээр мэдээллэж байгаа болно.

-Шалгалт бүрэн дууссан байгууллагууд:

1. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ
2. Их шүтээн ОНӨААТҮГ
3. Үйлс бадрах ӨЭМТөв
4. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан
5. 20-р цэцэрлэг
6. 5-р цэцэрлэг
7. 2-р цэцэрлэг
8. 16-р цэцэрлэг
9. Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сан

10. 11-р цэцэрлэг
11. 24-р цэцэрлэг
12. 19-р цэцэрлэг
13. 4-р цэцэрлэг
14. 3-р цэцэрлэг
15. 21-р цэцэрлэг
16. Хотын захирагчийн алба **(төлөвлөгөөт бус)**
17. 10-р цэцэрлэг
18. 4-р сургууль
19. 8-р сургууль
20. “Жаргалант ус дулаан түгээх станц” ОНӨХК **(төлөвлөгөөт бус)**
21. Оюу цэцэрлэг
22. Одод цэцэрлэг
23. Баян-Өндөр сумын ОНХСан
24. Татварын газар
25. 20-р сургууль
26. Гаалийн газар
27. Худалдан авах ажиллагааны газар
28. Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар
29. 1-р сургууль
30. Бялзуухай цэцэрлэг
31. 7-р цэцэрлэг
32. 17-р цэцэрлэг **(төлөвлөгөөт бус)**
33. Хот тохижуулах газар
34. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
35. Эрдэнэт сан
36. Жаргалант сумын Болзошгүй аваарын зардал
37. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
38. Теле камер хяналтын дэд төв
39. Зэст багийн амралт чөлөөт цагийн талбайн тохижилтын ажил **(төлөвлөгөөт бус)**
40. Биеийн тамир спортын газар
41. 2-р сургууль
42. 13-р сургууль
43. Хотын захирагчийн алба
44. Орхон аймгийн музей
45. Архивын хэлтэс
46. 14-р сургууль
47. Жаргалант сумын ЗДТГ
48. Баян-Өндөр сумын ЗДТГ
49. Баян-Өндөр сумын Болзошгүй аваарын зардал
50. 1-р цэцэрлэг
51. 16-р сургууль
52. Эрдэнэт-ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК
53. Уран эгшиг сургууль

Дээрх байгууллагуудын гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт, албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажиллаж байна.

-Шалгалт бүрэн дуусаагүй байгууллагууд:

1. Жаргалант сумын ОНХСан

2. Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль
3. Ирээдүйн одод сургууль
4. Нийтийн номын сан
5. Аймгийн Засаг даргын Тамгын газар
6. Төрийн байгууллагуудын албан хаагчдын цалин хөлсний нэмэгдэл

Дээрх байгууллагуудын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

1.2. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 86 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит гүйцэтгэлээ. (***Засгийн газрын тусгай сан-3, орон нутгийн төсвийн байгууллага-73, ОНӨХК-2, ОНӨААТҮГазар-6, Баян-Өндөр сум, Жаргалант сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал-2***)

2026 оны 3-р улирлын аудитаар :Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн нэгдсэн дүн **98.0%** байна. Үүнд:

- *Хуулийн хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан байдал: 14* байгууллага 20 талбарт хуулийн хугацаа хоцорч мэдээлэл байршуулг **99.4**% байна.
- *Мэдээлсэн талбараас дутуу буюу иж бүрэн бус мэдээлсэн талбар: 34* байгууллага 55 талбарт иж бүрэн бус мэдээлэл байршуулж **98.5%** байна.

86 байгууллагаас:

46 байгууллага -100%,
27 байгууллага -95-99%,
13 байгууллага -90-94% -тай тус тус дүгнэгдлээ.

2. СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН:

2.1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "7:4:10" вебинар цахим-вебинар мэдээллийн цагийн хөтөлбөрөөр зохион байгуулагдсан **3 удаагийн** сургалтад давхардсан тоогоор **11 албан хаагч** хамрагдлаа.

- 2026.11.05-ны өдөр “Үе хоорондын ялгаатай байдлыг ойлгож манлайлах нь” сэдэвт сургалтад 2 албан хаагч
- 2026.11.12-ны өдөр “Хүний хөгжил: Өнөөдөр ба ирээдүй” сэдэвт сургалтад 6 албан хаагч
- 2026.11.19-ний өдөр “Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын шинэчлэл”, “Төрийн жинхэнэ албаг хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмыг шинэчлэл” сэдэвт сургалт ёс зүйн хорооны 3 гишүүн

2.2. Дотооддоо зохион байгуулсан төлөвлөгөөт сургалт:

- Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран 11 дүгээр сард 4 удаагийн 4 цагийн Англи хэлний ярианы анхан шатны сургалтад албан хаагчдыг хамруулаа.




- 2026.11.23-ны өдөр “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар”-тай хамтран **“Сэтгэл зүйн EQ чадамж”** сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 11 албан хаагч хамрагдсан.





2.3. Дээд шатны байгууллагаас зохион байгуулагдсан **2 удаагийн** сургалтад давхардсан тоогоор **5 албан хаагч** хамрагдсан.

- 2026.11.11-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “И-оффис системд өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сангийн системийн хөгжүүлэлт, ашиглалтад холбоотой мэдээлэл” сэдэвт цахим сургалтад ХШҮХМ, Архив бичиг хэргийн эрхлэгч нар
- 2026.11.12-ний өдөр Монгол Улсын Ёс зүйн хороо, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн бодлого, үйл ажиллагаа", "Төрийн байгууллагын соёл", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ хийх, хариу арга хэмжээний төлөвлөлт" сэдэвт танхим, цахим хосолсон сургалтад Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн тус тус хамрагдсан.

3.ҮҮРЭГ ДААЛГАВАР: 11 дүгээр сард Засаг даргын өргөтгөсөн шуурхайгаас **1 үүрэг даалгавар** ирснийг хэрэгжилтийг ханган ажилласан. Үүрэг даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд и-оффис системд хааж, биелэлтийн тайланг аймгийн ХШҮХ-т тухай бүр хүргүүлсэн.

ОНЦЛОХ АЖИЛ, МАНЛАЙЛАЛ:

- Дэлхийн 146 оронд салбартай Монголын Үндэсний Дотоод Аудиторын Холбоо (IIA Mongolia Chapter)-оос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Дотоод аудиторуудын форум” энэ жил холбоо үүсэн байгуулагдсны 10 жилийн ойн хүрээнд **“Дотоод аудитын хувьсан өөрчлөлт”** сэдвийн дор 2026 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын болон хувийн хэвшлийн 450 гаруй Дотоод аудитор, эрсдэл, хяналтын мэргэжилтэн оролцож, дотоод аудитын салбарын хөгжил, чиг хандлага, шинэлэг арга барил, сайн туршлагаа хуваалцсан.

Тус форум арга хэмжээгээр үеэр:

1. "ДОТООД АУДИТЫГ СУРТАЛЧЛАХ САРЫН АЯН"-НЫ ЯЛАГЧ БАЙГУУЛЛАГА
2. "2026 ОНЫ ШИЛДЭГ ДОТООД АУДИТОР"
3. "2026 ОНЫ ШИЛДЭГ ДОТООДЫН НЭГЖ" салбарын шилдгүүдийг тодруулсан.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР НЬ Улсын салбараа манлайлан анх удаагаа 2 номинацын шилдгээр тодорлоо. Үүнд:

1. "ДОТООД АУДИТЫГ СУРТАЛЧЛАХ САРЫН АЯН"-НЫ ЯЛАГЧ БАЙГУУЛЛАГА
2. "2026 ОНЫ ШИЛДЭГ ДОТООД АУДИТОР"-оор газрын Ахлах мэргэжилтэн, Дотоод аудитор-Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Л.Булганцэцэг шалгарлаа.







12 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД:

- Төлөвлөгөөт хяналт шалгалт хуваарийн дагуу явагдана.
- Цаг үеийн болон төлөвлөгөөт бус байгууллагад холбогдох арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцоно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР